

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДСЭНИЙ ТӨВ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2017 оны 10 дугаар сарын 12 өдөр

№.09

Улаанбаатар хот

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 12 ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Арилжааны зохицуулалтын 2017 оны эхний хагас жилийн тайлан

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

.... Эхний хагас жилийн байдлаар ЭХЗХ-оос баталсан мөнгөн урсгалын коэффициентын тооцооноос үүссэн ашиг 9,5 тэрбум төг, НХА-ийн хуримтлагдсан ашиг 15,9 тэрбум төгрөг байна.

НХА-ийн түгээлтийн төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад эхний хагас жилийн байдлаар 84,4 сая кВт.ц буюу 3,4%-иар өсөлттэй байна. Үүнд: ДЦС 3 ХК 13,7 сая кВт.ц, ДЦС 4 ХК 78,4 сая кВт.ц, ДДЦС 6,4 сая кВт.ц, тус тус хэтэрсэн, Ухаахудаг 6,2 сая кВт.ц-аар дугуу түгээсэн байна.

Харин сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн хувьд “Солар Повер Интернейшнэл” ХХК-ийн Нарны цахилгаан станц нь нэгдсэн системд холбогдсон анхны нарны станц бөгөөд ТЗХ-ын шийдвэрээр үйлдвэрлэлийн төлөвлөгөөг хасаж төлөвлөсөн, бодит байдалд нарны эрчимжилтээс хамаарч 3,6 сая кВт.ц-аар илүү үйлдвэрлэсэн.

“Салхит” СЦС нь техникийн гэмтэл, саатлаас диспетчерийн графикийн хазайлт гаргаж, эхний хагас жилд өссөн дүнгээр 23.25 сая.кВт.ц (-) зөрчилтэй, үүний 13.18 сая.кВт.ц нь техникийн гэмтэл, саатлын улмаас үйлдвэрлээгүй ба төлөвлөгөөний саналаа буруу ирүүлсэнээс 10.49 сая.кВт.ц ЦЭХ-ийг үйлдвэрлэж чадаагүй байна... гэж тэмдэглэжээ.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Компанийн гүйцэтгэх захирал Д.Балдоржид үүрэг өгөх нь:

Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн горим төлөвлөлтөнд дараахь асуудлуудыг мөрдлөг болгон ажиллах. Үүнд:

1. Жилийн батлагдсан төлөвлөгөөг мөрдөх,
2. Сэргээгдэх эх үүсвэрүүдийн горим төлөвлөлтийг сайжруулан, гүйцэтгэлд нь хяналтыг тавьж ажиллахыг үүрэг болгох... гэжээ”.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ЧИМЭДДОРЖ